



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/136

Арвайхээр

Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 21 нас хүрээгүй хүнд утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

2.Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийн худалдаанд хяналт тавих, өсвөр үе, хүүхэд залуучуудад электрон тамхины хор уршгийг таниулах, тамхинд донтохоос урьдчилан сэргийлэх, зөв дадалд уриалах арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, арга хэмжээний үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (А.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0291

Аймгийн Засаг даргын 2022 оны  
03 дугаар сарын 13-ны өдрийн  
1136 дугаар захирамжийн  
хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Гишүүд: Ж.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Ж.Энх-Амар (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Нямсэмжаан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль, эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)

Б.Туяацэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч)

Э.Есөн-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)

Г.Амардэлгэр (Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын Өвөрхангай аймаг дахь улсын байцаагч)

Т.Цэдэнсодном (аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)